



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/67

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.6, Онцгой комиссын 2022 оны 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн 12 суманд өвөлжилт хүндэрч, гадны 14 аймгийн 80 суманд оторлож байгаа 803 өрхөд малын тэжээлийн үнийн дэмжлэг болох 56,210,000 (тавин зургаан сая хоёр зуун арван мянга) төгрөгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх онцгой эрсдэл үүсэж, өвлийг хохирол багатай даван туулах зорилгоор сумдын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3.Дээрх зардал болох 56,210,000 (тавин зургаан сая хоёр зуун арван мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамж гарсанаар 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Хөрөнгө зарцуулах тухай" А/571 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0143

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дүгээр  
захирамжийн хавсралт



ГАДНЫ АЙМАГТ ОТРООР ӨВӨЛЖИЖ БАЙГАА МАЛЧДАД  
ОЛГОХ МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ҮНИЙН ДЭМЖЛЭГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Сумын нэр	Гадны аймагт оторлож байгаа малчин өрхийн тоо	Нэг өрхийн 70,0 мянган төгрөг	Дэмжлэг үзүүлэх мөнгөн дүн (мянган төгрөг)
1	Баян-Өндөр	75	70,0	5250,0
2	Бүрд	42	70,0	2940,0
3	Бат-Өлзий	6	70,0	420,0
4	Баянгол	146	70,0	10220,0
5	Гучин-Ус	14	70,0	980,0
6	Есөнзүйл	57	70,0	3990,0
7	Өлзийт	110	70,0	7700,0
8	Зүүнбаян-Улаан	13	70,0	910,0
9	Богд	27	70,0	1890,0
10	Нарийнтээл	2	70,0	140,0
11	Сант	111	70,0	7770,0
12	Тарагт	12	70,0	840,0
13	Төгрөг	42	70,0	2940,0
14	Хайрхандулаан	4	70,0	280,0
15	Хужирт	40	70,0	2800,0
16	Хархорин	32	70,0	2240,0
17	Арвайхээр	70	70,0	4900,0
		803		56210,0